

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 04-р сарын 22-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 15:00 цагт, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-24 хаягт орших, “Холидэй Инн” зочид буудлын хурлын танхимд танхимаар зохион байгуулж, хуралдууллаа.

Хурлын цаг: 15:00-18:10,

Хурлын байршил: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-24 хаягт орших, “Холидэй Инн” зочид буудлын хурлын танхим,

Хурлын дарга: С.Сүхболд,

Хурлын нарийн бичгийн дарга: Г.Баярбаатар,

Хурлын ирц: Нийт саналын эрх бүхий 343,132,157 хувьцаанаас 319,120,376 ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 93%,

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай,
2. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,
3. ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай,
4. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай,
5. “Сүү” ХК-ийн 2024 оны эхний хагас жилийн ногдол ашиг тараалтын тайлан болон 2024 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг тараах талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх,

Хэлэлцсэн нь:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай,
2. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,
3. ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай,
4. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай,
5. “Сүү” ХК-ийн 2024 оны эхний хагас жилийн ногдол ашиг тараалтын тайлан болон 2024 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг тараах талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх,

Танилцуулсан нь:

Хурлын дарга: Эрхэм хүндэт хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид болон энэхүү шууд дамжуулалтыг хүлээн авч үзэж буй нийт хэрэглэгч, харилцагч, бэлтгэн нийлүүлэгчид та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилж байна.

Та бүхэнд “Сүү” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг танилцуулъя.

Хурлын дарга хуралдааны дэгийг танилцуулав.

Одоо та бүхэнд “Сүү” ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссоос гаргасан хурлын ирцийн тухай тогтоолыг уншиж, танилцуулна уу хэмээн Тооллогын комиссын дарга Т.Дамдинсүрэнг тайзнаа урьж байна.

Тооллогын комиссын дарга Т.Дамдинсүрэн: Тооллогын комиссын №01 тогтоол уншиж, танилцуулав.

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2025 оны 04-р сарын 22-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

ХУРЛЫН ИРЦИЙН ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3 дахь хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ын ирцийг хурлын даргад МЭДЭЭЛЭХ нь:

1. “Сүү” ХК-ийн 2025 оны “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр байсныг дурдсугай.

2. Бүртгэлийн өдрөөр “Сүү” ХК-ийн нийт саналын эрхтэй хувьцааны тоо 343,132,157 ширхэг байснаас 2025 оны “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-д 319,121,590 эрхтэй, нийт 193 хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирснээр хурлын ирц 93% болж, хурлын ирц бүрдсэнийг мэдэгдсүгэй.

Тооллогын комиссын дарга: / Т.Дамдинсүрэн /

Гишүүд: / Ц.Бор-Охин /

..... / Н.Ууганбаяр /

Хурлын дарга: Компанийн тухай хуульд заасны дагуу хурлын ирц бүрдсэн байх тул “Сүү” Хувьцаат Компанийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал ийнхүү эхэлж байна.

Хурлыг нээж үг хэлнүү хэмээн Макс Группийн Ерөнхий захирал, “Сүү” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн Д.Цэрэнжигмэд хувьцаа эзэмшигчдэд хандан мэндчилгээ дэвшүүлнэ.

Макс Группийн Ерөнхий захирал, “Сүү” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн Д.Цэрэнжигмэд: Хувьцаа эзэмшигчдэд хандан мэндчилгээ дэвшүүлэв.

Хурлын дарга: Макс Группийн Ерөнхий захирал, “Сүү” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн Д.Цэрэнжигмэд танд баярлалаа. Одоо дэгийн дагуу хэлэлцэх эхний асуудал болох Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал байгаа. Үүнтэй холбоотой Үйл ажиллагааны тайлангийн танилцуулгыг “Сүү” Хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал ноён Б.Гантулга танилцуулна.

“Сүү” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Гантулга: Компанийн 2024 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалтай холбоотойгоор үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, байгаль орчин ба хүний эрх, танилцуулав.

Хурлын дарга: Хурлын хэлэлцэх асуудалтай холбоотойгоор Хөндлөнгийн аудитор нь 2024 оны санхүүгийн аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх асуудал юм.

Хөндлөнгийн БДО Аудит ХХК: 2024 оны санхүүгийн аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэв.

Хурлын дарга: Хөндлөнгийн аудитор БДО Аудит ХХК-д баярлалаа, одоо миний бие дор дурдсан мэдээллийг та бүхэнд танилцуулна.

- “Сүү” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын 2024 оны үйл ажиллагааны тайлан,
- Компанийн дотоод аудит, түүний тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт,
- Гүйцэтгэх удирдлагад олгох урамшууллын гүйцэтгэлийн шалгуур,
- Компанийн засаглалын кодексын хэрэгжилт,

Хурлын дарга: Дээрх мэдээллийг танилцуулав.

Хурлын дарга: Ийнхүү “Сүү” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг танилцуулна уу хэмээн Макс Группийн Ерөнхий захирал, “Сүү” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн Д.Цэрэнжигмэд таныг тайзнаа урьж байна.

Макс Группийн Ерөнхий захирал, “Сүү” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн Д.Цэрэнжигмэд: “Сүү” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт танилцуулав.

Хурлын дарга: Хурлын дэгийн дагуу дараагийн танилцуулъя.

- Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай,
- ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай,
- ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай,
- “Сүү” ХК-ийн 2024 оны эхний хагас жилийн ногдол ашиг тараалтын тайлан болон 2024 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг тараах талаар Хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

Хурлын дарга: Хэлэлцэх 2-5 дугаар асуудлуудыг танилцуулав.

Хурлын дарга: Та бүхэнд ийнхүү хэлэлцэх асуудлуудыг танилцууллаа. Хурлын дэгийн дагуу асуулт, санал, хүсэлт хүлээн авах үе шат эхэлж байна. Үүнтэй холбоотойгоор хурал 15 минут завсарлаж асуулт, санал, хүсэлт хүлээн авах бөгөөд энэхүү хугацаанд хувьцаа эзэмшигчид хурлын материалтай танилцан, зааварчилгааны дагуу асуулт, санал, хүсэлтээ ирүүлнэ үү. Баярлалаа

Хурал завсарлав.

Хурлын дарга: Хувьцаа эзэмшигчид идэвхитэй оролцож 10 асуулт ирүүлсэн байна. Энэхүү асуултуудыг Б.Гантулга захирлаас асууя.

1. Сүү ХК 2024 онд 16 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Энэ ашгийн хэдэн хувийг ногдол ашигт, хэдийг нь дахин хөрөнгө оруулалтад зарцуулсан бэ?
2. Цэвэр ашиг болон борлуулалт нэмэгдсэн ч P/E харьцаа буурсан үзүүлэлт гарсан байна. Компанийн үнэлгээ зах зээлд хангалттай байна гэж үзэж болох уу?
3. Suu 2.0 төслийн явц, хүлээгдэж буй ROI (Return on Investment)-ийн тооцоолол хэр байна вэ? Хэзээ бүрэн хэрэгжих вэ?
4. Давуу эрхийн хувьцаа гаргадаг уу?
5. 2025 оны төлөвлөгөө орлогын төсөөлөл?
6. Шинээр гаргах бүтээгдэхүүний талаар?
7. Өмнөх оны төлөвлөгөө, гүйцэтгэлээ дэлгэрэнгүй тайлбарлана уу?
8. 2025 оны голлох төлөвлөгөөг танилцуулна уу?
9. Сүү бэлтгэн нийлүүлэгчдэд хувьцаа олгосон энэ хөтөлбөр дахин хэрэгжих үү?

10. Компани дүрэмд нийт хувьцаа 344,000,000 болон өөрчилж байна. Ямар учиртай вэ?

Гүйцэтгэх захирал Б.Гантулга: хариулав.

Хурлын дарга: Хурлын дэгийн дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулах ёстой байгаа. Санал хураалттай холбоотой Саналын хуудасны загвар, санал хэрхэн өгөх зааварчилгааг энэхүү хурлаар хүргүүлж байгаа. Энэхүү зааварчилгаатай та бүхэн танилцсан гэдэгт итгэлтэй байна. Дэгийн дагуу хурал 20 минут завсарлана. Завсарлагааны дараа Тооллогын комисс хурлаар хэлэлцсэн асуудлуудтай холбоотойгоор Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн санал хураалтын дүнг нэгтгэн, гарсан тогтоолыг та бүхэнд танилцуулна.

Хурал завсарлав.

Хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдээс хурлаар хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулж дууссан байх тул нэгдсэн дүнг танилцуулна уу хэмээн Тооллогын комиссын дарга Т.Дамдинсүрэнг тайзнаа урьж байна.

Тооллогын комиссын дарга Т.Дамдинсүрэн: Тооллогын комисс хэлэлцэх асуудлуудтай холбоотойгоор Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн санал хураалтаар хэлэлцсэн асуудлаар гарсан саналын дүнг нэгтгэн, тогтоол гаргасан байгааг та бүхэнд уншиж танилцуулъя.

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ
2025 оны 04-р сарын 22-ны өдөр № 02 Улаанбаатар хот

САНАЛ ХУРААЛТЫН НЭГДСЭН ДҮНГИЙН ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3 дахь хэсэг, “Сүү” ХК-ийн 2025 оны “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-д санал хураалтаар хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн санал хураах хуудсыг тоолсон тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Сүү” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон нийт 319,121,590 ширхэг хувьцаа эзэмшиж буй 193 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдээс нийт 319,086,725 ширхэг, 99%-н хувьцаа эзэмшиж буй 69 хувьцаа эзэмшигч саналаа ирүүлсэн бөгөөд үүнээс 319,086,725 ширхэг хувьцаа эзэмшиж буй 69 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүчин төгөлдөрт тооцсугай.

2. Ердийн журмаар санал өгөх хувьцааны тоог 343,132,157 ширхэгээр тогтоосугай.

3. Саналын хуудсаар “Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай” асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 99 % зөвшөөрсөн, - % татгалзсан байгааг мэдэгдсүгэй.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
319,086,725	99%	-	-%	-	-%

4. Саналын хуудсаар “Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 99 % зөвшөөрсөн, - % татгалзсан байгааг мэдэгдсүгэй.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
319,086,725	99%	-	-%	-	-%

5. Саналын хуудсаар “ТУЗ-ийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, ТУЗ-ийн гишүүдийг кумулятив аргаар сонгох тухай” асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 99 % зөвшөөрсөн, - % татгалзсан байгааг мэдэгдсүгэй.

№	Батлагдсан тогтоолууд		ТУЗ-ийн гишүүний төрөл / Хараат бус гишүүн эсхүл ердийн гишүүн /	Зөвшөөрсөн хувьцааны санал		Татгалзсан хувьцааны санал	
				Тоо	Хувь	Тоо	Хувь
1	ТУЗ-ИЙН	С.Сүхболд	Ердийн	319,083,512	8.33		
2	ГИШҮҮДИЙГ	Д.Жамъян	Ердийн	319,083,392	8.33		

3	ЧӨЛӨӨЛЖ, ТОМИЛОХ ТУХАЙ	Д. Уянга-Лянхуа	Ердийн	319,087,285	8.33		
4		Д.Цэрэнжигмэд	Ердийн	319,103,429	8.33		
5		Д.Тунгалаг	Ердийн	319,084,698	8.33		
6		Д.Ганбаатар	Ердийн	319,083,698	8.33		
7		Б.Түвшинтөгс	Ердийн	319,083,119	8.33		
8		Б.Гантулга	Ердийн	319,096,939	8.33		
9		Г.Баяр	Хараат бус	319,082,997	8.33		
10		Н.Цэрэндорж	Хараат бус	319,079,364	8.33		
11		Б.Батзориг	Хараат бус	319,081,322	8.33		
12		Д.Давааням	Хараат бус	319,080,136	8.33		
13		Б.Алтангэрэл	Хараат бус	1,481	0.001%		
14		Н.Улаанхүү	Хараат бус	3,584	0.001%		
15		Т.Түвшинсайхан	Хараат бус	3,437	0.001%		
16		Г.Оюунболд	Хараат бус	2,307	0.001%		

6. Саналын хуудсаар "ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай" асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 99 % зөвшөөрсөн, - % татгалзсан байгааг мэдэгдсүгэй.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
319,086,610	99%	-	-%	115	0.001%

Тооллогын комиссын дарга: / Т.Дамдинсүрэн /
 Гишүүд: / Ц.Бор-Охин /
 / Н.Ууганбаяр /

Хурлын дарга: Тооллогын комисст баярлалаа. Одоо Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан тогтоолыг уншиж танилцуула.

"СҮҮ" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоол

2025 оны 04-р сарын 22-ны өдөр № 01 Улаанбаатар хот
 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ
 ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг, "Сүү" ХК-ийн 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн №02 тоот "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал"-ын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

3. "Сүү" ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА С.СҮХБОЛД

"СҮҮ" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоол

2025 оны 04-р сарын 22-ны өдөр № 02 Улаанбаатар хот

"СҮҮ" ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг, "Сүү" ХК-ийн дүрмийн 8 дугаар бүлэг болон "Сүү" ХК-ийн 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн №02 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- "Сүү" ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, компанийн дүрмийн эхийг Хавсралт №1 ёсоор баталсугай.
- "Сүү" ХК-ийн шинэчилсэн дүрэм холбогдох тогтоол, шийдвэрийг эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг "Сүү" ХК-ийн Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА С.СҮХБОЛД

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04-р сарын 22-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ ЧӨЛӨӨЛЖ, ТОМИЛОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн дүрмийн 8 дугаар бүлэг болон “Сүү” ХК-ийн 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн № 02 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгосугай.
2. “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

№	Овог/ нэр	Гишүүний төрөл
1	С.Сүхболд	Ердийн
2	Д.Жамъян	Ердийн
3	Д. Уянга-Лянхуа	Ердийн
4	Д.Цэрэнжигмэд	Ердийн
5	Д.Тунгалаг	Ердийн
6	Д.Ганбаатар	Ердийн
7	Б.Түвшинтөгс	Ердийн
8	Б.Гантулга	Ердийн
9	Г.Баяр	Хараат бус
10	Н.Цэрэндорж	Хараат бус
11	Б.Батзориг	Хараат бус
12	Д.Давааням	Хараат бус

ХУРЛЫН ДАРГА

С.СҮХБОЛД

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04-р сарын 22-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн дүрмийн 8 дугаар бүлэг болон “Сүү” ХК-ийн 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн № 02 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг дараах байдлаар тогтоож, 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгосугай. Үүнд:

№	Албан тушаал	Тухайн жилд олгох цалин, урамшууллын нийт хэмжээ
1.	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга болон гишүүд	Компанийн өмнөх жилийн нийт ашгийн 0.7%

2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд олгох цалин, урамшууллын нийт хэмжээний хүрээнд гишүүний цалин урамшууллыг нарийвчлан тогтоон, шийдвэрлэх эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.

ХУРЛЫН ДАРГА

С.СҮХБОЛД

Хурлын дарга: Ийнхүү тогтоол уншиж танилцуулсан тул 2025 оны Сүү ХК-ийн ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурал хаасныг мэдэгдье.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

Хянасан:

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДАРГА:



/Г.БАЯРБААТАР/

/С.СҮХБОЛД/